



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн дахин санал хураалт явагдахтай холбоотой тодорхой асуудлаар аудит хийж, дүгнэлт гаргах нийцлийн аудитын тайлан

**Сонгуулийн сурталчилгаа дуусгаснаас хойш
сурталчилгаатай дүйцэхүйц үйл ажиллагаа явуулж
Сонгуулийн тухай хуулийг зөрчжээ**

Улаанбаатар хот
2017 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Аудит хийсэн үндэслэл	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ	3
Аудитын арга зүй.....	3
Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа.....	3
Ерөнхий мэдээлэл.....	5
Нэг. Сонгуулийн сурталчилгаа дуусгаснаас хойш сурталчилгаатай дүйцэхүйц үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээгээр явуулж, Сонгуулийн тухай хуулийг зөрчжээ	6
Хоёр. Иргэдийн өр төлбөрийг төрийн мэдлийн тодорхой эх үүсвэрээс барагдуулахтай холбоотой шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх нь Монгол Улсын Ерөнхийлөгчид хуулиар олгосон бүрэн эрх биш байна	7
Гурав.Иргэдийн зээлийн өрийн үлдэгдлийг тодорхой эх үүсвэрээс барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд Монгол Улсын нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар гарах эрсдэлтэй	7
Дүгнэлт.....	8
Зөвлөмж.....	9
Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал.....	10

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
АН	Ардчилсан Нам
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах тогтоолын төсөл хэлэлцэх үед Төсвийн Байнгын хорооны даргаас өгсөн чиглэл, Орон Нутгийн Сонгогчдын Эрх Ашгийг Хамгаалах Нийгэмлэгээс ирүүлсэн албан бичгийн дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн дахин санал хураалтад Ардчилсан намаас нэр дэвшин оролцож байгаа Х.Баттулга болон Ардчилсан намын зүгээс сонгуулийн сурталчилгаа хаагдсан үед олон нийтийн саналыг татах агуулгатай, сонгуулийн сурталчилгааны шинжтэй, сонгуулийн тухай хууль тогтоомжоор хориглосон заалтад хамаарах “Монгол хүн бүрийг нэг удаа өргүй болгох тухай” мэдэгдлийг хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр тарааж байгаа нь Сонгуулийн тухай хууль тогтоомжид нийцсэн эсэхийг нягтлан шалгаж, дүгнэлт гаргах, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд энэхүү аудитын зорилт чиглэгдсэн.

Тухайн аудитад Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн дахин санал хураалтад Ардчилсан намаас нэр дэвшин оролцож байгаа Х.Баттулга болон Ардчилсан намын зүгээс олон нийтийн цахим сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулж байгаа мэдээлэл, мэдэгдэлтэй холбогдуулан 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хооронд явагдсан үйл ажиллагааг хамруулан шалгасан болно.

Аудитын арга зүй

Тухайн аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг мөрдлөг болгохын зэрэгцээ дараах ерөнхий горим, арга зүйг ашиглана. Үүнд:

- хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарсан холбогдох мэдээллийг цуглуулж, нягтлан шалгах;
- олон нийтийн сүлжээгээр тархсан холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- тухайн асуудлаар шаардлага ирүүлсэн ТББ-ын төлөөлөлтэй ярилцлага хийх;
- аудитын явцад цуглуулсан мэдээлэл, бүрдүүлсэн нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх.

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Холбогдох бусад хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам.
- Бусад холбогдох хууль, эрхийн акт

ҮАГ-т ирүүлсэн шаардлага, холбогдох асуудлын мөн чанар, ач холбогдлоос шалтгаалан тус аудитыг маш яаралтай буюу 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс 06-ны өдрийн хооронд ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням хянан удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Энхбаатар хэрэгжүүлэн, ахлах аудитор Д.Отгонбаяр, аудитор А.Ариунзаяа нар хариуцан гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

ҮАГ-аас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.18-д “Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрт дүгнэлт гаргах” болон Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-т “... мөрийн хөтөлбөр нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцсэн байдалд болон хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг төрийн аудитын байгууллагаар хянуулсан байна.” гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргасан болно.

Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулгын мөрийн хөтөлбөрт иргэдийн өр төлбөрийг төрийн мэдлийн тодорхой эх үүсвэрээс барагдуулахтай холбоотой зорилт, арга хэмжээ огт тусгагдаагүй бөгөөд тус мөрийн хөтөлбөр болон түүнд өгсөн дүгнэлтийг ҮАГ-ын цахим хуудсанд байршуулсан болно.

Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4.2 дахь “уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн болон бусад салбарын орлого, түүнчлэн улс, орон нутгийн төсвөөс иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх”, 67.4.3 дахь “зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх” гэсэн заалтуудад сонгуулийн мөрийн хөтөлбөрт дээрх агуулга бүхий амлалт тусгахыг хориглодог.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн дахин санал хураалтад Ардчилсан намаас нэр дэвшин оролцож байгаа Х.Баттулга болон Ардчилсан намын зүгээс иргэдийн өр төлбөрийг улсын төсвөөс барагдуулахтай холбоотой амлалт авсан, сонгогчдын саналыг худалдан авахад чиглэсэн хууль бус үйл ажиллагаа явуулсан, сурталчилгааны агуулга бүхий нэвтрүүлэг хийж, олон нийтэд цахим сүлжээгээр түгээсэн тухай мэдээлэл ирсэн.

Энэ асуудлыг тодруулж үзэхэд Ардчилсан намын дарга С.Эрдэнийн гарын үсэг бүхий 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/21 дугаартай “Монгол хүн бүрийг нэг удаа өргүй болгох тухай” албан бичгээр “... нийт иргэдийнхээ одоо байгаа зээлийн өрийн үлдэгдлийг байгалийн баялгаас иргэдэд хүртээх өгөөж болон иргэдэд эзэмшүүлэх хувьцааны ногдол ашгаар төлүүлэх”, “... стратегийн ач холбогдол бүхий орд газруудын үр өгөөжөөс иргэдэд шууд хүртээх буюу уул уурхайн салбарын томоохон компаниудын төрийн мэдлийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулж, хувьцаа хэлбэрээр иргэдэд эзэмшүүлж, ногдол ашиг хуваарилж, орлогын тогтвортой эх үүсвэртэй болгох” зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулгад даалгасан тухай мэдээлэл, тухайн даалгавар бүхий албан бичиг зэрэг нь олон нийтийн цахим сүлжээгээр өргөн тархсан нь бодитой байна.

Үүнээс гадна олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээнд “өргүй Монгол”, “иргэдийн өрийг чөлөөлөх”, “иргэдийн өрийг төлөх” зэрэг агуулгатай богино хэмжээний сурталчилгаа, мэдээлэл түгээмэл байна.

СЕХ-ны бүрэн эрхийн талаар Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т “...сонгуулийн хууль, тогтоомжийн биелэлтэд хяналт тавих” гэж заажээ.

Эдгээр нөхцөл байдалд үндэслэн энэхүү аудитыг батлагдсан зорилт, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн, дүгнэлт, зөвлөмж бэлтгэлээ.

Нэг. Сонгуулийн сурталчилгаа дуусгаснаас хойш сурталчилгаатай дүйцэхүйц үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээгээр явуулж, Сонгуулийн тухай хуулийг зөрчжээ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн сурталчилгаа хийх эрх бүхий этгээд болох АН-аас 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөр “Монгол хүн бүрийг нэг удаа өргүй болгох тухай” албан бичгээр тус намаас нэр дэвшигч Х.Баттулгад иргэдийн өр төлбөрийг төрийн мэдлийн тодорхой эх үүсвэрээс барагдуулахыг даалгасан мэдэгдлийг гардуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээжээ.

Олон нийтийн саналыг татах агуулгатай, сонгуулийн сурталчилгааны шинжтэй, сонгуулийн тухай хууль тогтоомжоор хориглосон амлалтад хамаарах “иргэдийн өр төлбөрийг барагдуулах” мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр түгээсэн нь Сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт “Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс хорь хоногийн өмнө эхлүүлж санал авах өдрөөс нэг хоногийн өмнө дуусгана”, мөн 70 дугаар зүйлийн 70.5.2-т “зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх” гэсэн хориглосон заалтыг зөрчсөн байна.

АН-аас өөрийн нэр дэвшигч Х.Баттулгад даалгасан “... нийт иргэдийнхээ одоо байгаа зээлийн өрийн үлдэгдлийг байгалийн баялгаас иргэдэд хүртээх өгөөж болон иргэдэд эзэмшүүлэх хувьцааны ногдол ашгаар төлүүлэх”, “... стратегийн ач холбогдол бүхий орд газруудын үр өгөөжөөс иргэдэд шууд хүртээх буюу уул уурхайн салбарын томоохон компаниудын төрийн мэдлийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулж, хувьцаа хэлбэрээр иргэдэд эзэмшүүлж, ногдол ашиг хуваарилж, орлогын тогтвортой эх үүсвэртэй болгох” зэрэг арга хэмжээ нь тус нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй, мөн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгахыг хориглосон арга хэмжээг тодорхойлсон Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4.3-т “зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх” гэсэн заалтад хамаарч байна.

Түүнчлэн ҮАГ-аас хянаж, дүгнэлт гаргасан тус нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дээрх арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд дээрх мэдээллийг сурталчилгааны шинжтэйгээр мэдээллийн хэрэгслээр төрөл бүрийн хэлбэрээр, давтамжтайгаар түгээж байгаа нь Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5.4-т хориглосон “сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах” гэсэн заалтад хамаарч байна.

Хоёр. Иргэдийн өр төлбөрийг төрийн мэдлийн тодорхой эх үүсвэрээс барагдуулахтай холбоотой шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх нь Монгол Улсын Ерөнхийлөгчид хуулиар олгосон бүрэн эрх биш байна

АН-аас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч Х.Баттулгад тус намаас даалгасан иргэдийн зээлийн өрийн үлдэгдлийг барагдуулах, стратегийн ач холбогдол бүхий орд газруудын үр өгөөжөөс иргэдэд шууд хүртээх, уул уурхайн салбарын томоохон компаниудын төрийн мэдлийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, ногдол ашиг хуваарилах үйл ажиллагаа Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12, 13, 14, 15 дугаар зүйлд тус тус заасан Ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрхэд хамаарахгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд дээрх асуудлаар хууль санаачлан боловсруулах тохиолдолд нийгэм, эдийн засаг, иргэдийн амьдралд үзүүлэх нөлөө, үр дагаврыг урьдчилан судалж, үндэслэлтэй тооцооллыг хийж УИХ-д өргөн мэдүүлэх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд заасны дагуу зөвхөн Улсын Их Хурал тухайн асуудлыг эцэслэн шийдвэрлэх бүрэн эрхтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж, Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн...” гэж, Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.” гэж тус тус заасан байдаг.

Гурав. Иргэдийн зээлийн өрийн үлдэгдлийг тодорхой эх үүсвэрээс барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд Монгол Улсын нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар гарах эрсдэлтэй

Монголбанкны цахим хуудас дахь статистик мэдээллийн санд байршуулсан “Иргэд, ЖДҮ-д олгосон зээлийн тайлан”-гаас үзэхэд 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар банк, санхүүгийн байгууллагаас иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 5,860.8 тэрбум төгрөг байгаа нь Монгол Улсын 2017 оны дотоодын нийт бүтээгдэхүүний 22 хувьтай тэнцүү, Монгол Улсын 2017 оны улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөсөн дүнгээс 40 орчим хувиар илүү, банк, санхүүгийн байгууллагаас олгосон нийт зээлийн үлдэгдлийн 47 орчим хувьтай тэнцүү байна.

Иргэдийн их хэмжээний зээлийн өрийг ийнхүү барагдуулах амлалтыг өгч байгааг мэргэжлийн байгууллага, хувь хүмүүс, экспертүүд эсэргүүцэн хүлээн авч, эдийн засаг, санхүүгийн үр дагаврын талаар сэрэмжлүүлсэн мэдээлэл олон нийтийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ихээхэн гарч байна.

Түүнчлэн банк, санхүүгийн салбараас олгосон нийт зээлийн 47 хувийг бүрдүүлж байгаа иргэдийн зээлийн эргэн төлөлтөд хүлээлт бий болох, улмаар банк, санхүүгийн системийн хэвийн, найдвартай үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлтэй байна.

Ардчилсан Нам нь нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй, сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгахыг хориглосон арга хэмжээ бүхий олон нийтийн саналыг татах агуулгатай, сонгуулийн сурталчилгааны шинжтэй мэдэгдэлийг сонгуулийн сурталчилгааг дуусгаснаас хойш олон нийтийн цахим сүлжээгээр түгээж Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5.4 дэх заалтад “сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах”, 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт “Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс хорь хоногийн өмнө эхлүүлж санал авах өдрөөс нэг хоногийн өмнө дуусгана”, мөн 70 дугаар зүйлийн 70.5.2-т “зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх” гэж хориглосон заалтуудыг тус тус зөрчсөн байна.

АН-аас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч Х.Баттулгад тус намаас даалгасан иргэдийн зээлийн өрийн үлдэгдлийг барагдуулах, стратегийн ач холбогдол бүхий орд газруудын үр өгөөжөөс иргэдэд шууд хүртээх, уул уурхайн салбарын томоохон компаниудын төрийн мэдлийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, ногдол ашиг хуваарилах үйл ажиллагаа нь хууль, тогтоомжийн дагуу Ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрхэд хамаарахгүй байна.

Иргэдийн зээлийн өрийн үлдэгдлийг төрийн мэдлийн тодорхой эх үүсвэрээс барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд Монгол Улсын нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар гарах эрсдэлтэй байна.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Сонгуулийн Ерөнхий Хороонд:

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т “...сонгуулийн хууль, тогтоомжийн биелэлтэд хяналт тавих” гэж заасан эрх үүргийн хүрээнд аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажиллах.

Орон нутгийн сонгогчдын эрх ашгийг хамгаалах нийгэмлэг ТББ-д:

Сонгуулийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.1 дэх хэсэгт “... аливаа этгээд тухайн орон нутаг дахь цагдаагийн байгууллагад гомдол, мэдээлэл гаргана”, 117 дугаар зүйлийн 117.2 дахь хэсэгт “...ирүүлсэн гомдол, мэдээллийг шүүгч шийдвэрлэнэ” гэж заасныг үндэслэн холбогдох хуулийн байгууллагад хандах боломжтойг анхаарах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/146

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн дахин санал хураалт явагдахтай холбоотой тодорхой асуудлаар аудит хийж, дүгнэлт гаргах" нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Сонгуулийн Ерөнхий Хороо, Орон нутгийн сонгогчдын эрх ашгийг хамгаалах нийгэмлэг ТББ-д тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажилахыг Сонгуулийн Ерөнхий Хорооны дарга Ч.Содномцэрэнд зөвлөсүгэй.

4. Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Сонгуулийн тухай хууль, тогтоомжийн дагуу холбогдох хууль хяналтын байгууллагад хандах боломжтой болохыг Орон нутгийн сонгогчдын эрх ашгийг хамгаалах нийгэмлэг ТББ-ын тэргүүн Д.Батболд зөвлөсүгэй.

5. Аудитын тайлан, ажлын баримт, нотлох зүйлийг зохих журам, зааврын дагуу архивын нэгж болгон байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэлийн аудитын газар /М.Давааням/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_KheregiTushaal\2017\0706NAG01.Docx

070623

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ТЭМДЭГЛЭЛ

This image shows a full page of white paper with horizontal dashed lines, typical of primary school writing paper. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.